

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/018/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторовын Орлогч: Я.Самбууням

Утас: 51-261885 Цахим хаяг:
sambuunyamy@audit.gov.mn

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг

Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас: 260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Батцэцэг
Утас: 261628 Цахим хаяг: battsetsegp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

「СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ДАРГА П.ДЭЛГЭРНАРАН ТАНАА

2025.04.25 № 1599
танай _____-ны № _____-т

「 Хязгаарлалттай дүгнэлт 」

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сонгуулийн ерөнхий хорооны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 501.1 сая төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийг холимог тогтолцоогоор явуулж Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх /мажоритар/ аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ аргаар сонгон, анх удаа Улсын Их Хурлын 126 гишүүнийг сонгох сонгуулийг амжилттай зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн зардалд 32,180.3 сая төгрөг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн зардалд 37,599.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардалд 3,431.2 сая төгрөг, нийт 73,210.5 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 69,969.6 сая төгрөг зарцуулсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 200 дугаар тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахад шаардлагатай нэмэлт зардалд 8,826.5 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 8,783.2 сая төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сонгуулийн байгууллагын хүртээмж, мэдээллийн солилцооны үр ашгийг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангах зорилгоор www.e-election.mn цахим системийг хөгжүүлж сонгуулийн байгууллагад ажиллах төрийн албан хаагчийн бүртгэл, сургалтыг зохион байгуулах, нам эвсэл нэр дэвшигч болон сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, ухуулагч, ажиглагч, менежерийн бүртгэлийг цахим системээр хийж, үнэмлэхийг цахимаар олгон цаг хугацаа цаасны хэмнэлтийг гаргаж мэдээллийг шуурхай солилцох боломжийг бүрдүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name 'Д. Загджав' and the title 'Урьдчилсан гүйцэтгэл' (Interim Management).

Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,147,100.0	4,477,804.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,912,122.0	-
34	УРЬДЧИЛГАА	94.9	-
35	БАРАА МАТЕРИАЛ	4,234,883.1	4,477,804.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,940,569.4	13,385,839.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,940,569.4	13,385,839.1
39200	Биет хөрөнгө	11,912,757.6	12,784,568.8
39300	Биет бус хөрөнгө	1,027,811.7	601,270.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	21,087,669.3	17,863,643.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,912,122.0	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,912,122.0	-
41300	Өглөг	3,912,122.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,175,547.3	17,863,643.8
51	Засгийн газрын хувь оролцоо	17,175,547.3	17,863,643.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	14,410,826.1	14,410,826.1
51200	Хуримтлагдсан үр дүн	2,764,721.2	3,452,817.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	21,087,669.3	17,863,643.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	27,948,238.8	83,984,526.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,755,749.2	5,160,744.0
120	Нийтлэг татварын бус орлого	12,755,749.2	5,160,744.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,192,489.6	78,823,782.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	16,847,543.1	82,927,453.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,587,021.4	82,927,453.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,172,175.7	81,805,066.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,094,598.7	1,616,609.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,859.9	200,921.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,347.0	5,170.0
2104	Хангамж, бараа материалын зардал	94,811.8	230,624.7
2107	Томилолт, зочны зардал	18,891.8	53,229.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	440,050.9	447,688.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,382,615.6	79,250,823.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	414,845.7	1,122,386.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,260,521.7	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	11,100,695.7	1,057,073.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	368,976.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	11,100,695.7	688,096.4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,074,851.6	-	6,074,851.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,074,851.6	-	6,074,851.6
9	Тайлант үеийн үр дүн	11,100,695.7	-	11,100,695.7
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,175,547.3	-	17,175,547.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,175,547.3	-	17,175,547.3
19	Тайлант үеийн үр дүн	688,096.4	-	688,096.4
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,863,643.8	-	17,863,643.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	19,104,856.6	78,865,753.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,912,367.0	225.0
120	Нийтлэг татварын бус орлого	3,912,367.0	225.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,192,489.6	78,865,528.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,932,212.9	78,705,358.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,932,212.9	78,705,358.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,517,367.2	77,541,050.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,094,598.7	1,616,609.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,859.9	200,921.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,347.0	5,790.0
2104	Хангамж, бараа материалын зардал	45,191.0	48,259.6
2107	Томилолт, зочны зардал	18,891.8	53,229.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	444,096.2	451,470.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,773,382.6	75,164,770.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	414,845.7	1,164,307.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	15,172,643.7	160,395.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	11,260,521.7	4,072,517.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,260,521.7	4,072,517.3
2200	Дотоод эх үүсвэрээр	11,260,521.7	4,072,517.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(11,260,521.7)	(4,072,517.3)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,912,122.0	(3,912,122.0)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,912,122.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,912,122.0	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,210,587,500.00	68,969,629,286.26	(4,240,958,213.74)	94.2
УРСГАЛ ЗАРДАЛ	73,210,587,500.00	68,969,629,286.26	(4,240,958,213.74)	94.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,157,464,200.00	68,918,214,783.48	(4,239,249,416.52)	94.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,348,860,600.00	1,616,609,385.94	(732,251,214.06)	68.8
Үндсэн цалин	1,372,496,300.00	979,597,776.21	(392,898,523.79)	71.4
Нэмэгдэл	740,649,600.00	366,786,281.58	(373,863,318.42)	49.5
Унаа хоолны хөнгөлөлт	137,389,100.00	139,763,377.20	2,374,277.20	101.7
Урамшуулал	98,325,600.00	130,461,950.95	32,136,350.95	132.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	293,607,700.00	200,921,700.54	(92,685,999.46)	68.4
Тэтгэврийн даатгал	199,653,200.00	138,297,033.84	(61,356,166.16)	69.3
Тэтгэмжийн даатгал	23,488,600.00	16,248,213.63	(7,240,386.37)	69.2
ҮОМШӨ-ний даатгал	11,744,300.00	8,671,006.66	(3,073,293.34)	73.8
Ажилгүйдлийн даатгал	11,744,300.00	7,305,257.62	(4,439,042.38)	62.2
Эрүүл мэндийн даатгал	46,977,300.00	30,400,188.79	(16,577,111.21)	64.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,918,900.00	5,790,000.00	(2,128,900.00)	73.1
Байрны түрээс	7,918,900.00	5,790,000.00	(2,128,900.00)	73.1
Хангамж, бараа материалын зардал	49,381,500.00	48,259,625.62	(1,121,874.38)	97.7
Бичиг хэрэг	6,347,400.00	6,139,250.00	(208,150.00)	96.7
Тээвэр, шатахуун	23,835,100.00	24,092,864.00	257,764.00	101.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,896,200.00	14,875,211.62	(1,020,988.38)	93.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,302,800.00	3,152,300.00	(150,500.00)	95.4
Эд хогшил, урсгал засварын зардал	147,960,000.00	117,318,560.00	(30,641,440.00)	79.3
Багаж, техник, хэрэгсэл	74,760,000.00	71,218,560.00	(3,541,440.00)	95.3
Тавилга	73,200,000.00	46,100,000.00	(27,100,000.00)	63.0
Томилолт, зочны зардал	62,469,400.00	53,229,230.03	(9,240,169.97)	85.2
Гадаад албан томилолт	54,819,500.00	53,229,230.03	(1,590,269.97)	97.1
Дотоод албан томилолт	7,649,900.00	0	(7,649,900.00)	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	465,978,400.00	451,470,275.00	(14,508,125.00)	96.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	454,048,800.00	439,646,415.00	(14,402,385.00)	96.8
Даатгалын үйлчилгээ	11,127,500.00	11,055,760.00	(71,740.00)	99.4
Тээврийн хэрэгслийн татвар	190,000.00	156,000.00	(34,000.00)	82.1
Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	519,300.00	519,300.00	-	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	26,800.00	26,800.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	69,781,287,700.00	66,424,616,006.35	(3,356,671,693.65)	95.2

Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураантайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	69,779,335,700.00	66,422,716,006.35	(3,356,619,693.65)	95.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,952,000.00	1,900,000.00	(52,000.00)	97.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,123,300.00	51,414,502.78	(1,708,797.22)	96.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	38,631,800.00	37,354,502.78	(1,277,297.22)	96.7
Засгийн газрын гадаад шилжүүлэг	38,631,800.00	37,354,502.78	(1,277,297.22)	96.7
Бусад урсгал шилжүүлэг	14,491,500.00	14,060,000.00	(431,500.00)	97.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,491,500.00	14,060,000.00	(431,500.00)	97.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	73,210,587,500.00	68,969,629,286.26	(4,240,958,213.74)	94.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73,210,587,500.00	68,969,629,286.26	(4,240,958,213.74)	94.2
Улсын төсвөөс санхүүжих	73,210,587,500.00	68,969,629,286.26	(4,240,958,213.74)	94.2
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
Төсвийн байгууллага	2	2	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	47	47	-	100.0
Удирдах ажилтан	4	4	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	43	43	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	47	47	-	100.0
Ажлын албаны албан хаагч (АА)	45	45	-	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		8,825,151,971.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,825,151,971.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,783,230,858.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		8,783,230,858.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		8,783,230,858.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		41,921,113.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		41,921,113.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		41,921,113.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		8,825,151,971.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		8,825,151,971.00
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,825,151,971.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 9,027.5 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Аудитаар нийт 501.1 сая төгрөгийн 7 зөрчил² илэрснээс, 501.1 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар илэрсэн 501.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Түүвэрт хамруулсан байгууллага дээр алдаа зөрчил илрээгүй байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн дээрх 501.1 сая төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

3.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.3 "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 41 дүгээр зүйлийн 41.2.3 "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Монгол Улсын Засгийн газрын 444 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4.2.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтаар, тохируулгын тайланг мөн журмын 10 дугаар хавсралтад заасан маягтаар, төсвийн гүйцэтгэлийн зарлагын нэгтгэлийг мөн журмын 11 дүгээр хавсралтад заасан маягтаар тус тус гарган төв төрийн санд Төсвийн тухай хуульд заасан хугацаанд хүргүүлнэ", Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журмын 2 дугаар хавсралтаар тайлагнах гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг заавар журмын дагуу бэлтгэж ажиллах.

2. Урьдчилж төлсөн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Даатгалын хураамж, программын лиценз зэргийн төлбөрийг урьдчилж гарсан зардал дансанд хуримтлуулж, тайлант хугацаанд ногдох зардлыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй, нийт дүнгээр шууд зардалд тусгаж үр дүнг бууруулсан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 9 дүгээр бүлгийн 9.3-т “...Урьдчилж төлсөн зардал гэж хэд хэдэн тайлант үед хамаарах зардлыг урьдчилан төлсөнтэй холбоотой үүссэн зардлыг хэлнэ” 9.5.а-д “төлсөн төлбөрийг урьдчилж төлсөн зардлаар бүртгэнэ”, 9.5.б-д “хэрэгжсэн үед зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ...” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”; гэж заасантай нийцээгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэглээний программын лиценз, даатгалын төлбөрийг Урьдчилж гарсан зардал дансанд бүртгэх, өртгийг ашиглах хугацаанд хуваарилан зардлаар бүртгэх, цаашид бүртгэлийг стандартад нийцүүлэн сайжруулах.

3. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох журмын дагуу өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно гэж заасны дагуу нөхөн олговор олгохдоо санхүүгийн жилийн хугацаанд 2 удаагийн шийдвэрээр 3 удаагийн өөрчлөлт орсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.5-д “Төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх удирдлагын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлж төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн тогтвортой байдлыг ханган ажиллах.

4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой 125.3 сая төгрөгийн 13 нэр төрлийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшилд дахин үнэлгээ хийж, үнэ, ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоолгох асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1 Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх.

5. Хууль тогтоомжийн хэрэгжилт, ашиглалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2024 оны А/80 дугаар захирамжаар 4,802.7 сая, СЕХ-ны Тамгын газрын даргын 2024 оны А/72 дугаар тушаалаар 170.0 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг харьяа байгууллагад шилжүүлэхдээ эрх зүйн үндэслэлийг буруу тусгасан байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5-д “Зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх”; Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн

эрхийг хэрэгжүүлнэ" 14.2.10 "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" , Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, 6 дугаар зүйлийн 6.6.1-т "Төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөв захирагчийн бүрэн эрхийн хүрээнд төсвийг захиран зарцуулж, захирамж, тушаалын үндэслэлийг оновчтой тодорхойлж, зорилгодоо нийцсэн эрх зүйн акт гаргах, шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтны эрх үүргийг зааглаж, тодорхой болгох.

6. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 57.0 сая төгрөгийн 13 удаагийн гүйлгээгээр тийзний төлбөр шилжүүлэхдээ аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулалгүй шилжүүлж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг гарахаас нь өмнө анхны шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, үнийн дүн багатай, давтан гарах шинжтэй ажил гүйлгээг гарахаас нь өмнө ижил түвшний байгууллагуудаас үнийн санал авч харьцуулалт хийж төсвийг хэмнэлттэй зарцуулж хэвших.

7. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мэдээ, мэдээлэл контент бэлтгэн түгээх ажлын хүрээнд нийт 139.7 сая төгрөгийн ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа журамд заасны дагуу багцалж зохион байгуулах комиссыг томилоогүй, аж ахуйн нэгж байгууллагуудтай шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2022 оны А/06 дугаар захирамжийн хавсралтаар баталсан "Сонгууль зохион байгуулж явуулах батлагдсан төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын 2.6-д "Ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тохиолдолд худалдан авах ажиллагааг багцалж зохион байгуулах комиссыг энэ журамд заасны дагуу байгуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тохиолдолд журмын дагуу багцалж, ижил түвшний байгууллагуудаас үнийн санал хүлээн авч харьцуулсны үндсэн дээр төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж хэвших.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Үүнээс				Зөвлөмж	
				Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сонгуулийн ерөнхий хороо	1	160.4	1	160.4				
		1	41.9	1	41.9				
		1	8,825.1	1	8,825.1				
Нийт		3	9,027.4	3	9,027.4				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сонгуулийн ерөнхий хороо	1	-			0	-	1	-		
	1	9.0					1	9.0		
	1	-					1	-		
	1	125.3					1	125.3		
	1	170.0					1	170.0		
	1	57.0					1	57.0		
	1	139.8					1	139.8		
НИЙТ	7	501.1	-	-	-	-	7	501.1	-	-